



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

「 Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 25,685,531 (хорин таван сая зургаан зуун наян таван мянга таван зуун гучин нэг) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслүүдийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.


3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс /Б.Батбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасуй.

ДАРГА



М. БАЯРАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2022 оны 02 сарын 17 -ны өдрийн
 А/53 тушаалын хавсралт



СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
 ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	Авеко 24-00 БРА	2008/2008	Тусгай БНХАУ Хөх алаг	LNVAICA247 VL08715	215251	20,685,531	Хөдөлгүүр нь хэт элэгдэн гильзний орой хэсгээрээ хөмсөг сууж хормой хэсгээр хагаралт, босоо зураас үүсэж сунасан, поршингийн хормой цохигдсон, кольц элэгдсэн зэргээс битүүмж алдагдаж асалтгүй болсон, хөдөлгүүрийн крышканы нударган голын хүзүүнүүд дуу орж цохио үүссэн, тосон клапангууд гацсан, тахир гол хэт элэгдэж суларсанаас хүзүүнүүдэд цохио үүссэн
2		Ниссан адван 55-57 БРА	2011/2017	Суудал ЯПОН Хөх алаг	097351	300267	5,000,000	
нийт							25,685,531	